

ЯЛТАЙ БАЙДЛЫН ЭРХ ЗҮЙН ПРОЦЕССИЙН ЗАРИМ АСУУДАЛ

CERTAIN LEGAL PROCEDURAL MATTERS OF ACCUSATION PERIOD

**Ц.МӨНХБАТ**

Улсын ерөнхий прокурорын туслах, Ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих хэлтсийн дарга

MUNKHBAT TS.

Associate Prosecutor General of Mongolia, chief department for supervision over sentence serving

Товч агуулга: Улсын Их Хурлаас 2015 онд баталсан “Өршөөл үзүүлэх тухай” хуулинд заасан ялгүй болох хугацаанаас үлдсэн хугацааг хэрэгсэхгүй болгох тухай заалтыг нэг мөр хэрэгжүүлэхэд эрх зүйн процессын хувьд төвөгтэй байдал үүссэнийг судалж санал дүгнэлт гаргахад оршино.

Abstract: This study is for research and solve complex situation and procedural law related to consistent use of dismissing remaining accusation period of “Law of forgiveness” approved by Mongolian Parliament in 2015.

Түлхүүр үгс: Ялтай байдал, Өршөөл үзүүлэх тухай хууль, шүүхийн практик.

Key words: Accusation period, law of forgiveness, court practices.

“Ялтай байдал”-ын талаар тухайлбал шүүхээр ял шийтгүүлсэн этгээдийг 2015 оны “Өршөөл үзүүлэх тухай” хуульд хамааруулж ялаас чөлөөлсөн тохиолдолд ялгүй болох хугацаанаас үлдсэн хугацааг хэрэгсэхгүй болгох эсэх маргаан төр, хууль хяналтын байгууллагууд, эрдэмтэн, судлаачид, хувь хүмүүсийн дунд өрнөж эсрэг тэсрэг байр сууриа илэрхийлсээр байна.

Өршөөлд хамааруулж зарим хугацааг хэрэгсэхгүй болгох. Тухайлбал: а) Хорих ялыг тэнссэн хүний хянан харгалзах хугацаа, б) Хорих газраас тэнсэн суллагдсан хүний хянан харгалзах хугацаа, в) Жирэмсэн эмэгтэй, гурав хүртэлх насны хүүхэдтэй эх буюу ганц бие эцэг, насанд хүрээгүй хүнд хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан хугацаанаас тус тус үлдсэн хугацааг¹ хэрэгсэхгүй болгох заалтыг хэрэгжүүлэх процесс нь хэн бүхэнд тодорхой байна. Учир нь дурдсан процессын ажиллагаа нь хэрэг

бүртгэх, мөрдөн байцаах, прокурор, шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хяналтанд байдаг тул хэрэгжилтийн явцад ямар нэгэн сөрөг асуудал гараагүй байна.

1990 оноос 2009 он хүртэл хууль тогтоох дээд байгууллага “Өршөөл үзүүлэх тухай” хуулийг 5 удаа баталж гаргасан ба тэдгээрт ялгүй болох хугацааг хэрэгсэхгүй болгох талаар заалт орсон ч одоог шиг анхаарлын төвд байгаагүй ба ялтай байдал нь төрийн аль ч байгууллагын хяналтанд ороогүй зөвхөн ялтай байхдаа гэмт хэрэг дахин үйлдсэн тохиолдолд ял оногдуулахдаа хүндрүүлэх нөхцөл байдалд буюу давтан гэж үзэх², ялгүйд тооцох буюу ялгүй болох хугацаа нь дуусаагүй тохиолдолд төрийн албанд авч ажиллуулахыг хориглох³ сонгуульд нэр дэвшихэд ял шийтгүүлж байгаагүй эсхүл ял шийтгүүлж байсан бол ялгүй

¹ “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. Өршөөл үзүүлэх тухай хууль. УБ., 2015. №31, 1671-р тал 4,5,6-р зүйл.

² Монгол Улсын Хууль эмхэтгэл. Эрүүгийн тухай хууль. УБ., 2015. 56-р зүйлийн 56.1.12 дахь хэсэг. 27-р тал

³ Төрийн албаны тухай хууль. 16-р зүйлийн 16.2 дахь хэсэг.

болсон буюу ялгүйд тооцогдсон байхад⁴ /Шинэ Эрүүгийн хуулинд ялтай байдал байхгүй болсон тул ял шийтгэлгүйг хэрхэн тооцох вэ/ “ач холбогдолтой” байна.

Улсын Дээд Шүүхийн тогтоолоор баталсан тайлбаруудад “ялтай байдал”-ын тухай нарийвчлан дурьдаагүй байна. Харин “Прокурорын байгууллагын тухай хууль”-ийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай Улсын Дээд шүүхийн 2002 оны 02 дугаар тогтоолд “...ял шийтгүүлж байгаагүй...гэсэн ойлголтод Эрүүгийн хуулийн 78.2-т заасан ялгүй болох хугацаа хамаарахгүй бөгөөд урьд өмнө шүүхээр огт ял шийтгүүлж байгаагүйг хэлнэ”. Энэ нь ялтан шүүхийн шийтгэх тогтоол хуулийн хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн түүнийг ялгүйд тооцох буюу ялгүй болох хүртэл хугацаанд ялтайд тооцогдоно⁵ гэсэн Эрүүгийн хуулийн заалт болон Улсын Дээд шүүхийн 2007 оны 41 дүгээр тогтоолоор Эрүүгийн хуулийн 181 дүгээр зүйлийн зарим заалтыг тайлбарлахдаа Эрүүгийн хуулийн 78 дугаар зүйлийн 78.2-т заасан ялгүй болох хугацаа өнгөрсөн, мөн зүйлийн 78.3-т заасан үндэслэлээр ялгүйд тооцогдсоны дараа шинээр гэмт хэрэг үйлдсэн бол урьд ял шийтгүүлсэнд тооцохгүй⁶ гэсэнтэй зөрчилдөж байна. Эндээс Улсын Дээд Шүүхийн ямарваа шийдвэр төгс биш буюу “туйлын үнэн”-ийг агуулаагүйг харж болно.

Өршөөл үзүүлэх тухай хуулиудад сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтныг энэ хуульд заасан эрх зүйн байдлыг нь дээрдүүлсэн, аль илүү ашигтай үндэслэлээр нэг удаа өршөөлд хамааруулна гэж заасан байна. Энд холбогдох этгээдийг өршөөлд хамааруулаад нэмж “ялтай байдал”-ын хугацааг хэрэгсэхгүй болгох эсэх нь эргэлзээтэй, зөвхөн шүүхийн үзэмжээр

шийдвэрлэж ирсэн байна.

Шүүхээр ял шийтгүүлсэн ялтнуудын хувьд ялтай байдал хэвээр үлддэг бөгөөд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд шалгагдаж буй сэжигтэн, яллагдагчийн хувьд ялтай байдал бий болдоггүй нь хүн бүр шүүхийн өмнө эрх тэгш байна гэсэн зарчмыг зөрчиж буй хэрэг юм⁷. Ялтай байдал нь ял шийтгэгдсэн этгээдэд эрх зүйн таагүй үр дагавар, эрхийн хязгаарлалтыг бий болгодог.

Шүүхийн зарим практикийг судлахад “ялтан Т нь Булган аймаг дахь сум дундын шүүхээр Эрүүгийн хуулийн тусгай ангийн 145 дугаар зүйлийн 145.2 дахь хэсэгт зааснаар 3 жил 1 сарын хорих ял шийтгүүлээд ял эдэлж байхад нь 2009 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн “Өршөөл үзүүлэх тухай” хуулийн 4 дүгээр зүйлийн 4.4 дэх хэсэгт заасан үндэслэлээр 2009 оны 7 дугаар сарын 22-ны өдрөөр тооцож түүний эдлээгүй үлдсэн 2 жил 2 сар 18 хоногийн хорих ялыг нь өршөөн хэлтрүүлжээ. Энэ тохиолдолд ялтай байдал нь Өршөөлийн хуульд хамрагдаагүй бөгөөд Өршөөлийн хуульд хамрагдан суллагдсан үеэс нь эхлэн Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 78 дугаар зүйлийн 78.4 дэх хэсэгт зааснаар ялгүй болох хугацааг тоолох нь үндэслэлтэй байна. 2009 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн Өршөөл үзүүлэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх хэсэгт зааснаар энэ хууль хүчин төгөлдөр болохоос өмнө ял эдэлж дууссан этгээдийн Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 78 дугаар зүйлийн 78.2 дахь хэсэгт заасан ялгүй болох хугацаанаас үлдсэн хугацааг хэрэгсэхгүй болгож байгаа тул дээрх заалт нь тухайн үед ял эдэлж байсан Т гэгчийн ялаа эдэлж байсан үед хамаарахгүйг ойлгоно⁸ гэж шүүхийн шийдвэрт дурьдсан байна.

Мөн Сүхбаатар дүүргийн шүүхийн

⁴ Сонгуулийн тухай хууль. 154 дүгээр зүйлийн 154.3.5 дахь хэсэг.

⁵ Монгол Улсын хууль эмхэтгэл. Эрүүгийн хууль. УБ., 2015. 78-р зүйл. 36-р тал.

⁶ Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар. УБ., 2013. 734 дэх тал.

⁷ Г.Оюунболд. “Өршөөлийн хуулийн үр нөлөө” судалгааны тайлангийн эмхэтгэл (2010-2011). I-II. УБ., 2012.

⁸ Булган аймгийн давж заалдах шатны шүүхийн 2011 оны 2 дугаар сарын 9-ний өдрийн 5 дугаар магадлалыг үзнэ үү.



МОНГОЛ УЛСЫН
ДЭЭД ШҮҮХИЙН
ТОГТООЛ

2009 оны 11 дүгээр сарын 26-ны өдрийн 191/А дугаартай шийтгэх тогтоолоор Ц-г Эрүүгийн хуулийн тусгай ангийн 147 дугаар зүйлийн 147.2 дахь хэсэгт зааснаар 4 жилийн хорих ялаар шийтгэж 2009 оны Өршөөл үзүүлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2 дахь хэсэгт зааснаар уг ялаас өршөөн хэлтрүүлсэн байх тул түүний ялтай байдлыг тооцох хугацааг давхардуулан өршөөх үндэслэл байхгүй гэжээ⁹. Түүнчлэн ялтай байдлыг дангаар нь өршөөлд хамааруулж шийдвэрлэсэн шүүхийн практик байхгүй байна. 2015 оны Өршөөл үзүүлэх тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.5 дахь хэсэгт¹⁰ “Ялгүй болох хугацаанаас үлдсэн хугацааг хэрэгсэхгүй болоход цагдаагийн байгууллагаас ялтны хувийн хэрэгт өршөөл үзүүлэх тухай зохих тэмдэглэгээг хийх” тухай заасан ба энэ нь 1990 оноос хойш хийгдээгүй ба прокурорын хяналтын эрх зүйн зохицуулалтад ч ороогүй байна.

Маргаан үүсгэж буй тулгамдсан нэг асуудал нь 2009 оны Өршөөл үзүүлэх тухай хуулиар үйлдсэн гэмт хэрэг нь өршөөлд хамаарагдаж ялаас чөлөөлөгдсөн этгээдийн “ялтай байдал” нь 2015 оны “Өршөөл үзүүлэх тухай” хуулинд зааснаар хэрэгсэхгүй болгогдох ёстой талаар судлаачид үзэл бодлоо илэрхийлж байна.

Академич С.Нарангэрэл: “2009 оны Өршөөл үзүүлэх тухай хуулийн “ялтайд тооцох үлдсэн хугацааг нь өршөөн хэлтрүүлсүгэй” заалтад ... Эрүүгийн хуулийн 263 дугаар зүйл өршөөгдсөн. Тэгэхээр ялтайд тооцох хугацаа нь 2009 онд шийдвэрлэгдсэн гэсэн үг. Одоо энэ тал дээр ярих хууль зүйн асуудал байхгүй. Энэ бол одоо яригдаад байгаа шиг маргаад, мэтгэлцээд, олон тайлбар хэлээд байх шаардлагагүй асуудал. Маш энгийн хуулийн заалтаар л асуудал шийдэгдсэн. 2009 оны хуулиар

263 дугаар зүйл хязгаарлалтад ороогүй, бүрэн өршөөн хэлтрүүлсэн тул ялтайд тооцох хугацаанд мөн хязгаар байхгүй”¹¹ гэж хэлжээ.

Улсын Их хурлын гишүүн Х.Тэмүүжин: Намрын өршөөлийн хуулиар /2015 он/ ялтай байдлыг бүгдийг өршөөсөн. Хэн нэгэн хүнд зориулж энэ хуулийг гуйвуулж тайлбарлаж болохгүй. Хууль нэг мөр хэрэгжих ёстой. Өршөөлийн хуулиар “ялтай байдал” гэдэг заалтыг 100 хувь өршөөсөн. Өршөөлийн хууль батлагдахад протоколд тэмдэглүүлж байгаад миний хэлсэн үг бол “Энэ хууль гарснаар бүх гэмт хэргийн ялтай байдал өршөөгдлөө шүү” гэдгийг маш тодорхой хэлсэн¹² гэжээ. Гэвч хууль тогтоогчийн энэхүү санаа нь Өршөөл үзүүлэх тухай хуулинд тусгалаа олоогүй нийгмийг талцуулж байна.

Нөгөө талаар Өршөөл үзүүлэх тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3 дахь хэсэгт заасан гэмт хэрэг үйлдсэн хүнийг хамааруулахгүй үндэслэлээр дурдсан гэмт хэргийг үйлдээд тэнсэгдсэн, ял хойшлогдсон, ялгүй болох хугацаа зэрэгт бүхэлд нь хязгаарлалт тогтоосон гэж үзэж байгаа талаар хууль хяналтын байгууллагын эрх бүхий албан тушаалтнууд үндэслэл бүхий тайлбар гаргаж байна. Тухайлбал: “Өршөөл үзүүлэх тухай хуулинд хамааруулаагүй гэмт хэргийг үйлдэж шүүхээр ял шийтгүүлээгүй ба шийтгүүлээд суллагдсан хэний ч ялтайд тооцогдох хугацаа Өршөөлийн хуульд хамрагдахгүй¹³ гэсэн нэгдсэн байр суурьтай байна.

Ялаа эдэлж дууссан этгээд ялгүй болох хугацаанд гэмт хэрэг үйлдсэн ба шүүхээр ял шийтгүүлсэн эсэхээс үл хамааран ялгүй болох хугацаа нь тасрах ба Эрүүгийн хуулиар тогтоосон журмын дагуу ялаас хугацааны өмнө суллагдана гэдэгт зөвхөн хорих газраас хугацааны өмнө тэнсэн суллагдах биш, өөрөөр хэлбэл Монгол Улсын Ерөнхийлөгчийн

⁹ Улсын Дээд шүүхийн хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдааны 2014 оны 11 дүгээр сарын 26-ны өдрийн 413 дугаар тогтоолыг үзнэ үү.

¹⁰ Төрийн мэдээлэл эмхэтгэл. УБ., 2015. Дугаар 31. 1674 дэх тал.

¹¹ <http://www.fast.mn/>

¹² <http://www.trends.mn/>

¹³ <http://www.itoim.mn> 2016.12.16

зарлигаар уучлал үзүүлэх, Өршөөл үзүүлэх тухай хуульд хамрагдах, өвчний учир ялаас чөлөөлөгдөх болон бусад үндэслэлийг дурдаж болох юм.

ДҮГНЭЛТ

Тэгэхээр дурдсан нөхцөл байдалд дараах дүгнэлтийг хийж болохоор байна. Үүнд:

1. Ял эдлээд гарсны дараа хуульд заасан хугацаанд “ялтай байдал” үргэлжилдэг. Энэ ялтай байдал нь хүний эрхийг зөрчиж, эрх зүйн байдлыг дордуулж бусдаас ялгаварлахад хүргэсэн.

2. “Ялтай байдал” –ын талаар Улсын Дээд Шүүх албан ёсны тусгайлсан тайлбар гаргаагүй тул хуулийн байгууллагууд, төрийн албан тушаалтан, судлаачдын дунд ойлголт, хэрэглээний хувьд зөрчилдөөнтэй байдал үүсч, улс төржих хандлага бий болсон.

3. “Ялтай байдал”-д тавих хяналт хууль, журмаар зохицуулагдаагүй ирсэн байна.

4. 2015 оны Өршөөл үзүүлэх тухай хууль нь боловсруулалтын техникийн шаардлагыг оновчтой хангаагүйгээс ялтай байдлын талаар нийгмийн сэтгэл зүйд буруу ойлголт төрүүлэхэд нөлөөлсөн.

САНАЛ

Иймд “ялтай байдал”-ын талаар гарч буй маргаан мэтгэлцээнээс гарах ганц арга зам бол ял шийтгүүлсэн этгээд үндсэн ба нэмэгдэл ял эдэлж дууссаны дараа зан байдал, засрал хүмүүжлээрээ үлгэр жишээч байвал шүүх Эрүүгийн хуулийн 78 дугаар зүйлд заасан ялгүй болох хугацаанаас нь өмнө Эрүүгийн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасан үндэслэл журмын дагуу түүний ял шийтгүүлснээс үүссэн ялтай байдал гэсэн эрх зүйн үр дагаврыг хүчингүй болгож ялгүйд тооцож болох тухай¹⁴ хуулийн заалтын дагуу оршин суух газрын шүүхэд ял эдэлсэн этгээд, түүний өмгөөлөгч хүсэлт гаргаж шийдвэрлүүлэх нь зүйтэй юм.

¹⁴ Эрүүгийн байцаан шийтгэх хууль. УБ., 2012. 341-р зүйл.



Хууль сахиулахуй